

Огноо: 2024. 11. 08

№ 60

Улаанбаатар хот

“Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, “Төрийн банк” ХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсэг:

“4.12. Банк нь Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан мэдээллийг хуульд заасны дагуу хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлнэ.”

2/4 дүгээр зүйлийн 4.13 дахь хэсэг:

“4.13. Банк нь байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, хүний эрхийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг жил бүр нийтэд мэдээлнэ.”

3/11 дүгээр зүйлийн 11.13 дахь хэсэг:

“11.13. Энэ дүрмийн 10.11 дэх хэсэгт заасны дагуу түр томилогдсон ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-ийн гишүүний эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.”

4/15 дугаар зүйлийн 15.15 дахь хэсэг:

“15.15. Энэ дүрмийн 4.12-т заасан мэдээллийг нийтэд мэдээлэх, эрх бүхий байгууллагад тайлагнах үүргийг Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусгана.”

2. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13 дахь хэсгийн 10.13.9 дэх заалтын “тодорхойлох” гэсний дараа “эд хөрөнгийг акталж, данснаас хасах эсэх асуудлыг эрх бүхий байгууллагаас санал авсны үндсэн дээр шийдвэрлэх;” гэж нэмсүгэй.

3. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн дараах зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2. Банкны эрхэм зорилго нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгаль орчинд ээлтэй, хүний эрхийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, ногоон хөгжил, дундаж давхаргыг бойжуулах, дэмжихэд чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэй цахим технологи ашиглан тогтвортой, хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.”

2/10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэг:

“10.10. ТҮЗ-ийн гишүүнд Засгийн газар, эрх бүхий байгууллагаас тогтоосон жишгийн хүрээнд ТҮЗ-ийн дэргэдэх хороонд ажилласан байдлыг харгалzan нэмэгдэл цалин олгоно.”

3/10 дугаар зүйлийн 10.13 дахь хэсгийн 10.13.26 дахь заалт:

“10.13.26. Банкны байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого болон үйл ажиллагааны талаарх бодлого, журмыг батлах;”

4/11 дүгээр зүйлийн 11.1 дахь хэсэг:

“11.1. Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нь төрийг төлөөлөх ТҮЗ-ийн ердийн гишүүнд шаардлага хангасан нэр дэвшигчийг ТҮЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд Нэр дэвшүүлэх хороо тухайн нэр дэвшиж байгаа этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх талаар эрх бүхий байгууллагаас мэдэгдэл, зөвшөөрлийг авсны үндсэн дээр ТҮЗ-ийн ердийн гишүүнээр томилуулах саналаа ХЭХ-д танилцуулан шийдвэрлүүлнэ.”

5/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2 Төрийг төлөөлөх ТҮЗ-ийн ердийн гишүүд нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэж болно. Тухайн байгууллагаас хууль тогтоомжид заасан шалгуур хангасан албан хаагч томилох боломжгүй тохиолдолд Төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч шаардлага хангасан албан хаагчийг нэр дэвшүүлнэ.”

4. “Төрийн банк” ХК-ийн дүрмиин 22 дугаар зүйлийн 22.1 дахь хэсгийн “захирлуудын зөвлөлийн гишүүн” гэснийг “тэргүүн дэд захирал, дэд захирал, банкны төвийн газрын захирал, салбарын захирал” гэж тус тус өөрчилсүгэй.

5. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д үүрэг болгосугай.

6. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантэр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ТЭЛМҮҮН

